



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Ногоон хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөр батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны холбогдох шатны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Г.Баярсайхан - Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

А.Бакей - Улсын Их Хурлын гишүүн
Х.Болорчулуун - Улсын Их Хурлын гишүүн
С.Дэмбэрэл - Улсын Их Хурлын гишүүн
Я.Содбаатар - Улсын Их Хурлын гишүүн
Ц.Цолмон - Улсын Их Хурлын гишүүн
Л.Эрдэнэчимэг - Улсын Их Хурлын гишүүн


Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг:

Т.Булган - Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Ж.Ганбат - Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга
Г.Батхүрэл - Эдийн засгийн хөгжлийн яамны Хөгжлийн бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын дарга
Б.Галбадрах - Зам, тээврийн яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга
Л.Чой-Иш - Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга

- | | |
|---------------|---|
| Ц.Баярбат | -Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны газрын дарга |
| Д.Долгормаа | -Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга |
| Г.Товуудорж | -Эрчим хүчний яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга |
| Ч.Отгочулуу | -Уул уурхайн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга |
| Б.Бадамцэцэг | -Үндэсний статистикийн хороо, Макро эдийн засгийн статистикийн газрын дарга |
| М.Төрбаяр | -Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| Х.Хишигжаргал | -Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн |
| Г.Түмэнжаргал | -Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Цэвэр үйлдвэрлэл, цэвэр хөгжлийн газрын дарга |
| Д.Доржсүрэн | -“Цэнгэг усны хүрээлэн” ТББ-ын тэргүүн |

2.Дээрх Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны холбогдох шатанд хэлэлцүүлэх бэлтгэлийг тухай бүр нь хангаж ажиллахыг Ажлын хэсэг /Г.Баярсайхан/-т даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Г.БАЯРСАЙХАН